

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО /ЭМИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН
ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ ХЯНАН ШАЛГАХ/-НЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-1</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<hr/>	
<i>1. “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах, нотлох баримт гаргуулах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл</i>	<i>2-5</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан,
нөхцөлийг хянан шалгах/-ны 10 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 23 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Сандаг-Очир;

Чөлөөтэй: М.Оюунчимэг.

Нэг. “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах, нотлох баримт гаргуулах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах, нотлох баримт гаргуулах тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Д.Батлут, Б.Бейсен, Б.Жаргалмаа нар үг хэлэв.

Ж.Чинбүрэн: “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах, нотлох баримт гаргуулах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 0

Бүгд: 5

100 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Хуралдаан 15 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 38 минутад өндөрлөв

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
11 цаг 23 минут

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүддээ энэ өдрийн амгаланг айлтгая. Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны ирц бүрдсэн тул түр хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Түр хорооны ирцийг танилцуулъя. Дамбын Батлут гишүүн Орхон аймаг 20 дугаар тойрог ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар тойрог ирсэн байна. Буланы Бейсен Баян-Өлгий аймаг 2 дугаар тойрог ирсэн байна. Оюунчимэг гишүүн Чингэлтэй дүүрэг 25 дугаар тойрог одоо орж ирнэ. Жигжидсүрэнгийн Чинбүрэн 23 дугаар тойрог ирсэн. Цэвэгдоржийн Туваан Төв аймаг 14 тойрог ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн ажлын даалгаврыг батлах, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу. Нэмэлт саналтай гишүүд байхгүй байна.

Түр хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хянан шалгах түр хорооны хянан шалгагч нарыг томилсон байгаа. Өнөөдрийн хуралдаанаар хянан шалгагчийн ажлын даалгавар хэлэлцэж, нотлох баримт гаргуулах

тухай тогтоолын төслийг хэлэлцэж батална.

Та бүхэнд урьдчилан материал тараасан байгаа. Энэ дээр саналтай гишүүд саналаа хэлнэ.

Саналтай гишүүд нэрсээ өгөөрэй. Туваан гишүүн, Батлут гишүүн, Бейсен гишүүн нар санал өгсөн байна. Туваан гишүүний микрофоныг нээе.

Ц.Туваан: Ажлын даалгаврыг ерөнхийд нь танилцсан. Энэ дээр нэмэх нэг юм байгаа. Энэ нь эм дотор чинь бид бүхэн ганцхан европын анагаах ухааны эмүүд бас орохгүй, уламжлалт анагаах ухааны асуудлууд бас ордог. Тэгэхээр энэ дээр уламжлалт анагаах ухааны эм дээр импортын асуудал гэж юм байгаа. Тэгэхээр энэ нэлээн бас түүхий эд ч байна. Эм нь ч байна. Тэгэхээр энэ асуудлыг бүртгэлээс нь эхлүүлээд оруулж ирэх асуудал энэ тэр дээр төрийн байгууллагууд дээр ямар зарчмаар явагдаж байна. Бүртгэл. Мөн сая хэлсэн түүхий эдтэй холбоотой асуудал дээр нэмж даалгавар оруулах ийм санал гаргаж байна.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр Туваан гишүүн уламжлалт эмчилгээнд ашигладаг эм болон эмийн түүхий эдийн чанар аюулгүй байдлын асуудлыг оруулъя гэж томъёолж байна. Зөв үү. Бүртгэлээс эхлүүлээд. Хүлээж авлаа. Батлут гишүүний микрофоныг нээе.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ажлын хэсгийн хянагч нарын ажиллах ажлын хүрээнд олон асуудлыг оруулж өгсөнд баяртай байна. Гэхдээ нэмэх ганц нэг зүйлүүд байгаа санагдаж байна. Тухайлах юм бол, бид нар яг эрүүл мэндийн салбар тэр дундаа эмийн хэрэглээ тал дээр бол төр үнэндээ хяналтаа алдчихсан байгаа. Жишээлэх юм бол зөвхөн эм ханган нийлүүлэх байгууллага гэхээсээ илүүтэй цахим дээр янз бүрийн, төрөл бүрийн эмүүдийг борлуулахаар, худалдаалахаар

зар явдаг. Энийг бид нар бүрэн хянаж чадахгүй. Тэр нь эрүүл мэндийн үйлчилгээ идэвхжилт талдаа ямар байдаг юм. Хүний биед сөрөг, эерэг нь ямар нөлөөлөл үзүүлдэг юм гээд. Бид нар ямар нэгэн байдлаар баталгааг нь гаргаж чадахгүй байгаа, хянаж чадахгүй байгаагийн нөхцөл байдлууд илэрч байгаа юм. Тэгэхээр бид нар энэ цахим хэрэглээ тал дээр, цахимаар эм худалдан борлуулж байгаа асуудлуудыг хэрхэх вэ гэдгийг анхаарч үзмээр байна. Мэдээж энэ чинь эмийн хэрэглээ талдаа холбоотой асуудлыг ярьж байгаа учраас бүхий л талын болж бүтэхгүй байгаа бүхий л зүйлийг гаргаж ирж, асуудлыг тодорхойлж, шийдэл гаргах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр бид нар энэ цахим хэрэглээ тал дээр Цахим хөгжлийн яамтайгаа хамтаръя. Гаальтай хамтаръя. Хяналтын байгууллагуудтай хамтрах хэрэгтэй. Ингээд энэ цахим хэрэглээ дээр гарч ирж байгаа эмийн асуудлыг хэрхэх вэ, энэ байх ёстой юм уу, үгүй юу. Байвал ямар стандарт, шаардлага хангасан байх ёстой юм. Ямар бүртгэл. Нэг ёсондоо буух эзэн буцах хаягтай байх ёстой л гэсэн үг шүү дээ. Ямар байх ёстой юм бэ гэдэг дээр анхаарлаа хандуулж ажиллах нь зүйтэй. Тэгэхээр энэ талын асуудлыг оруулж өгөөч гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Энэ бол чухал асуудал л даа. Интернэтээр эмийн худалдаа бас их хийгдэж байгаа. Гадаадаас орж ирж байгаа эмийг иргэн өөрөө интернэтээс худалдаж аваад авч орж ирж байгаа. Тэр нь үнэхээр чанартай юм уу, үгүй юу гэдгийг бид мэдэж хэлж мэдэхгүй. Түүний зохицуулалт хууль, эрх зүйн орчин хүртэл ямар байгаа гэдгийг судлах л хэрэгтэй болж байгаа юм байна. Энэ саналыг хүлээж авлаа. Бейсен гишүүн.

Б.Бейсен: Эмийн үнийн өсөлттэй холбоотой нэг асуудал байна л даа. Тендерийн эмийн асуудал байгаа. Тендерийн эм дээр аптекуудын эмийн үнэ бас нэмэгддэг. Би түрүүн бас хэлж

байсан. Гаалийнхан тэгээд 8-15 хувийн нэмэгдлийн НӨАТ нэмдэг. Эм ханган нийлүүлэх байгууллагууд нь мөн 10 хувийн НӨАТ, тэгээд үнэ нь 25-35 хувь нэмдэг. Аптекууд мөн адилхан 35-40 хувь нэмдэг. Бас л 10 хувийн НӨАТ байгаа. Энэ асуудал яг хилээр оруулж ирж байгаа эмийн үнийг ханган нийлүүлэх байгууллагууд зохиомлоор өсгөж байна уу гэдгийг шинжээчид сайн судлах хэрэгтэй. Энийг дотоодын өсөж байгаа тэр эмийн үнийн асуудлыг бас яг тулгаж судлаад, тодорхой үнийн өсөл энэтэй холбоотой байх гэж бодож байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын гаргаж өгсөн судалгаа байгаа шүү дээ бид нарт. Та нар харвал тэр дээр бүр тэр байгууллага тодорхой гаргаж өгсөн байж байгаа. Тэгээд энэ талын судалгааг нь тэр шинжээчид нь сайн оруулж өгвөл зүгээр байх гэсэн санал хэлье.

Ж.Чинбүрэн: Ер нь бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эмийн үнийг буулгахад 8-10 аргачлал байдаг. Түүний нэгийг Бейсен гишүүн хэлээд байгаа. Гаальд хэдээр мэдүүлж байгаа юм. Давхардсан татварууд, НӨАТ-ын асуудлууд энэ бүгдийг бас шалгаж үзэх, гэхдээ хэдүүлээ зайлигүй шаардлагатай эм дотроо л орчихно гэж ойлгож байгаа тэр судалгаануудаа. Тэгэхгүй бол бүр халиад Монгол Улсын зах зээлд байгаа бүх эм рүү орох юм бол бид ажиллаж амжихгүй, дийлэхгүй. Тэгээд энэ ондоо юу ч хийж чадахгүй болох аюултай. Тэгэхээр хэдүүлээ зайлигүй шаардлагатай эм буюу өнөөдөр сая Эрүүл мэндийн яамны танилцуулж байгааг та бүхэн харж байгаа биз. Эмийн хөнгөлөлттэй худалдаж авч байгаа эмийн төсөв бараг 150 тэрбум төгрөг болж байна шүү дээ одоо. Бид анх Их Хурлын гишүүн болж байхад 27 тэрбум л байсан юм. Нэмсээр байгаад одоо 150. Тэгээд 150 тэрбум болж байгаа энэ их мөнгө нэмээд байдаг, энэ нь өөрөө яг бодитой юу гэдэг чинь бид нарын бас нэг шалгах ёстой ажил байхгүй юу. Тэгэхээр би бол тэр талаасаа хэдүүлээ

харж байна гэж ойлгож байгаа. Таны саналыг авлаа.

Жаргалмаа гишүүний микрофоныг нээгээрэй.

Б.Жаргалмаа: Би бас яг санал оруулахдаа түр хорооны хурлын өмнө бас зөвлөхүүд, референтүүдэд өөрийнхөө саналыг өгсөн байгаа. Яг бид нарын ажлын зорилго бол зайлиггүй шаардлагатай эмийн жагсаалт гэдэг зүйл байгаа. Би санал оруулахдаа ер нь бол түрүүн Туваан гишүүний хэлсэнчлэн зах зээлд худалдаалагдаж байгаа эм бэлдмэл, нэмэлт бүтээгдэхүүний чанарын асуудал гэж оруулсан юм. Сая Туваан гишүүний хэлж байгаа тэр тан гэхээр бас энэ дунд орчих болов уу гэж би бодоод байна л даа. Тэгэхээр сая даргын хэлж байгаагаар бид нар зайлиггүй шаардлагатай эмдээ хамаарахаар эд нар маань орохгүй гэсэн үг үү. Хэдүүлээ энэ асуудлыг шийдвэрлэхгүй бол болохгүй байх. Гэтэл нэмэлт бүтээгдэхүүн гэдэг үүднээсээ нөгөө л витамин, амин дэмүүд юу гэдэг ч юм жирэмслэлтээс хамгаалах эм энэ тэр бол бүртгэлд байдаггүй л байгаа шүү дээ. Тэгээд энэ бүгдийг ядаж хил гаалиар орж ирэхдээ бид нар хянадаг байх энэ тогтолцоог бий болгохгүй бол үргүйдэлд хүргэх эмийг жирэмслэлтээс хамгаалсан эм гээд зардаг байх жишээний ийм кейсүүд байдаг учраас бид нар энэ дээр оролцох, ажиллах, хянах зайлиггүй шаардлага байгаа юм гэдгийг би хэлье гэж бодлоо.

Нөгөөтээгүүр бид нар эмийн лабораториудын асуудлаар хяналт тавих ажил бас явагдаж байгаа. Монгол Улс бол Стандартчилал хэмжилзүйн газар байгаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн лаборатори түүнд ажилладаг байгаа. Өнөөдөр яг эмийн асуудал дээр ажиллаж байгаа эмийн лабораториуд маань яг стандартчиллын хувьд тэр хэмжээнд ажиллаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг хянахын тулд бид нар Үндэсний стандартчилал хэмжилзүйн газартайгаа хамтрах ёстой

байх. Олон улсын стандартчиллын хэм хэмжээнд тохирсон лаборатори ажиллаж байна уу, үгүй юу гэдгээ бид нар лабораторийн үйл ажиллагааг хянах зайлиггүй шаардлага байгаа учраас хэдийгээр бид нар ажлын даалгаварт орсон ч гэсэн Стандартчилал хэмжилзүйн газартай хамтрах хяналтаа хийгээсэй гэдэг ийм хүсэлтийг хэлэх гэсэн юм. Тэгэхээр бид нар зөвхөн зайлиггүй шаардлагатай эм үү, түрүүний Туваан гишүүний хэлсэнчлэн тан, түүхий эд, материал, амин дэм, витаминууд, бүртгэлгүй байгаа эмийг яаж хянах юм бэ гэдэг дээр саналаа хэлж байгаа юм.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Ер нь бас энэ хуурамч эм гэдэг нэр томьёо дотор ордог нэг зүйл бол хил гаалиар бүртгэгдээгүй эмүүдийг оруулж ирдэг явдал өөрөө ордог юм байна. Энэ чинь маш том байр суурь эзэлдэг юм байна. Тэгээд тэртэй холбоотой зөрчлийн тухай хууль дээр бид ямар ч бичиг баримт бүрдүүлэхгүйгээр витамин болон нэмэлт бүтээгдэхүүнийг оруулна, болно гээд хэлчихсэн. Тэр чинь маш ноцтой асуудал. Уг нь би бол хэлээд хэлээд ойлгуулж чадаагүй. Тэгэхээр энийг бол шалгах нь зүйтэй гэж бодож байна. Тэгээд энэ дээр зайлиггүй шаардлагатай эмийн жагсаалтад ороогүй, зах зээлд худалдаалагдаж байгаа гэдгээрээ оруулаад тэр дотроо эм, бэлдмэл, тан, энэ тэр гээд нэмээд оруулчихвал, нэмчихвэл Туваан гишүүний ч гэсэн хэлсэн зүйл орох юм байна. Тэгээд нэмэлт бүтээгдэхүүн гэж байгаа юм чинь чанар, аюулгүй байдалд дүн шинжилгээ хийж, тэдгээрийг сонголтоор авч үзээд тэр юуг судлах нь маш чухал. Энийг ерөөсөө бид заавал бүртгэж, энэ чинь ерөөсөө ганзагын наймаа яваад л байгаа юм. Энэ нь өөрөө чанаргүй эм Монголд байх нөхцөлийг бүрдүүлж өгөөд байгаа. Нэг бүхэл бүтэн том сүлжээ байна гэдэг мэдээлэл бидэнд байгаад байгаа. Тэгэхээр яг ажиллаад ирэхээр энэ гарах байх гэж бодож байна. Энэ дээр бол анхаарна. Саяны хэлсэн саналуудаас татгалзах зүйл нэг ч алга

байна. Бүгдийг нь нэмж оруулаад, тэгээд унших уу. Цахимыг бас нэмнэ. Уламжлалт эм, тэдгээрийн түүхий эд, мөн зайлиггүй шаардлагатай эмд ороогүй ч гэсэн биологийн нэмэлт болон витамин гэсэн ийм зүйлүүдийг оруулаад, тэгээд тогтоолыг төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураах уу.

Тэгвэл ийм байдлаар ажлын даалгаврыг баталъя гэдгээр санал хураая. Дэмжье гэсэн санал хураалт.

Нийт хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар батлагдлаа.

Гишүүд дээ баярлалаа. Хуралд идэвхтэй оролцсонд. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

11.38 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ